СЭДЭВ 5.
САНАЛ АВАХ ӨДӨР ИРГЭДИЙН ОРОЛЦОО

СОНГУУЛЬД САНАЛ ӨГӨХ ҮЙЛ ЯВЦ[22]

- Ээлжит сонгуулийн санал авах өдөр бүх нийтээр амарна. Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчид тухайн байгууллагын захиргаа нь чөлөө олгож, түүнийг санал өгөх боломжоор хангах үүрэгтэй.
- Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар санал авах ажиллагааг Улаанбаатарын цагаар өглөөний 07:00 цагаас оройн 22:00 цаг хүртэл явуулна.
- Гадаад улсад байгаа сонгогч Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх бөгөөд Улсын Их Хурлаас тогтоосон өдөр, тухайн улсын орон нутгийн цагаар 07:00 цагаас 22:00 цаг хүртэл хугацаанд Салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.

1. Сонгогч та саналаа өгөхөөр ирэхдээ иргэний үнэмлэхээ авч очно.
2. Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтанд хурууны хээгээ шалгуулан өөрийн иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэл, сонгогчийн нэрийн жагсаалтын цахим хувилбартай таарч байгаа эсэхээ тулган шалгуулна. Хурууны хээ уншигч сонгогчийн хурууны хээг танихгүй байгаа тохиолдолд иргэний үнэмлэхийн мэдээллийг шалган тухайн санал авах байранд бүртгэлтэй бол бүртгэлийн хуудас хэвлэж өгнө.
3. Сонгогчийн бүртгэлийн хуудсаа хүлээн авна.
4. Бүртгэлийн хуудсаа хүлээн авсан сонгогчид саналын хуудас өгч, сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна.
5. Сонгогч та саналын хуудас авч, санал бэлтгэх бүхээгт очиж саналаа нууцаар гаргах бөгөөд саналын хуудсанд саналаа тэмдэглэхдээ холбогдох зааврын дагуу тэмдэглэгээг хийнэ. Санал бэлтгэх бүхээгт тухайн сонгогчоос өөр хүн байхыг хориглодог.
6. Сонгогч нь нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн нэрийн өмнөх зуувин дугуйг зориулалтын үзгээр дүүргэн будаж тэмдэглэлээг хийнэ.
7. Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж (саналын хайрцаг)-д хийсний дараа санал авах байраас гарна. Ингэхдээ санал тоолох төхөөрөмжийн дэлгэцэнд “САНАЛЫН ХУУДАС АМЖИЛТТАЙ УНШИГДЛАА” гэсэн бичиг гарч иртэл түр хүлээх хэрэгтэй.

[22] *www.gec.gov.mn цахим хуудас. сонгогчийн булан*

Сонгогч дээр дурьдсаны дагуу саналаа тэмдэглэсэн саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж (саналын хайрцаг)-д хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.

- Тухайн сонгуулийн тойрогт ногдсон мандатын тооноос хэтрүүлэлгүйгээр нэр дэвшигчийн нэрийн өмнөх зуйван дугуйг бүрэн дүүргэж будаарай. Та хэдэн хүний төлөө санал өгөх боломжтойг саналын хуудасны дээд хэсэгт байрлах заавар болон санал бэлтгэх бүхээгт байрлуулсан зааварт тодорхой заасан байгаа тул сайтар уншиж танилцах хэрэгтэй.



- Саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжийн зориулалтын хэсэгт тулган барихад саналын хуудсыг автоматаар татаж авах болно.



- Саналын хуудсанд илүү тэмдэглэгээ хийсэн, санамсаргүйгээр бусад хэсэгт зураас үүсгэсэн зэргээс болж санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг автоматаар буцаадаг.
- Саналаа тэмдэглэхдээ дутуу будах, цэглэх, зөв юмуу хэрээс тэмдэг хийх зэргээр тэмдэглэвэл таны санал тоологдохгүй хүчингүй болох магадлалтай гэдгийг анхааараарай. Саналын хуудаст саналаа тэмдэглэхдээ гаргадаг алдаануудыг дараах зургаас харна уу.

Тухайлбал:



- Сонгогч санал өгөхдөө алдаа гаргаж, саналын хуудсанд буруу алдаатай хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа гаргах боломжийг хуулиар олгожээ.
- Бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болдог. Сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуулийн ажиглагч нь итгэмжлэгдсэн хүн байж болохгүй.

САНАЛ ӨГӨХӨД АНХААРАХ ЗҮЙЛСИЙГ ҮЗЭЭРЭЙ видео үзэх





Сонгогчоос саналаа өгөхөд дараах зүйлийг хориглоно:

- Тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх;
- Өөр хүний бичиг баримт, эсхүл хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох;
- Тухайн санал авах байраас олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах;
- Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;
- Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг үйлдэл хийх;
- Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах;
- Аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

Санал авах байранд дараах хүмүүс байх бөгөөд үүрэг нь:

- **Ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч** (нийт 5-7 хүн) – Санал авах байрны ахлах зохион байгуулагч нь өөрийн хэсэгт санал авах, тоолох ажлыг удирдан зохион байгуулж, хууль зүйн хариуцлагыг хүлээнэ. Нарийн бичиг, техникийн ажилтан, бүртгэлийн ажилтан, хөтөчийн үүрэг гүйцэтгэнэ.
- **Нам, төрийн бус байгууллагын ажиглагч, гадаадын ажиглагч** (нэг намаас дөрөв хүртэл ажиглагч, нэг ТББ-аас нэг ажиглагч тус, тус байж болно) – Ажиглагч нар нь хөндлөнгийн оролцогчийн хувиар сонгуулийн санал авах ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийг ажиглан, зөрчил гарсан тохиолдолд ахлах зохион байгуулагчид мэдэгдэнэ.
- **Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан** – Саналаа өгөхөөр ирсэн сонгогчийн хурууны хээг иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлтэй тулган сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.
- **Мэдээллийн технологийн даамал** – Санал авах, тоолох төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллана.
- **Цагдаагийн алба хаагч** – Сонгуулийн санал авах байрны аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ажиллана.

Сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтанд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- ✗ Сонгуульд оролцож байгаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах;
- ✗ Сонгуульд оролцож байгаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн болон эсэргүүцсэн агуулга бүхий үйлдэл хийх, үйл ажиллагаа явуулах;
- ✗ Сонгогчоос сонгуулийн эрхээ эдлэхэд нөлөөлөх, нөлөөлөхөөр оролдох;
- ✗ Санал хураах, тоолох ажилд саад хийх;
- ✗ Бусдыг төлөөлж санал өгөх;
- ✗ Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмжийн лац, битүүмжлэлийг гэмтээх;
- ✗ Гарын үсэг хуурамчаар үйлдэх;
- ✗ Саналын хуудас солих;
- ✗ Хүчингүй саналын хуудсаар санал авах;
- ✗ Хуулиар хориглосон бусад аливаа үйлдэл гаргах, зохион байгуулах, оролцох.

ДАСГАЛ АЖИЛ

Өмнө дасгал ажлаар танилцсан 2 нэр дэвшигчээ сонгож хэрхэн санал өгч өнөөдөр юу сурснаа шалгаарай. Мөн 2 нэр дэвшигчийн ялсан болон ялагдсан шалтгааныг ярилцаарай. Та бүгдийн өгсөн саналын хуудас бүгд хүчинтэй болсон байна уу? Үгүй бол ямар алдаа гарсныг ярилцаарай.

Та Монгол Улсын иргэний хувьд
төр барилцах эрхээ хэрхэн эдлэхээ
мэддэг боллоо.

Сонгогч Та өөрийн сонгосон төлөөллөөрөө
дамжуулан төрийн үйл хэрэгт оролцох эрхээ
эдэлж, сонголтоо хийхийн тулд мэдлэг,
мэдээлэлтэй байж, өөрийн итгэл үнэмшлээр
сайтар танилцан тунгааж, сонгуульдаа идэвхтэй,
шудрага, хариуцлагатай оролцоорой!

Та өнөөдрийн
сурсан мэдсэнээ бусадтай
хуваалцаж, сонгуульдаа
идэвхтэй оролцохыг
уриалаарай.